



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

“Ремикон” ХК-ийн хаалттай хүрээнд санал болгон нэмж
гаргасан хувьцааг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.8, 34.1.1 заалтыг тус тус үндэслэн, Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах Хорооны 2011 оны 340 дүгээр тогтоолоор үнэт цаасны бүртгэлд хаалттай хүрээнд нэмж бүртгэгдсэн “Ремикон” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 39,460,000 ширхэг энгийн хувьцааг анхдагч зах зээл дээр арилжаалагдаагүй нэг жилийн хугацаа өнгөрсөн байх тул уг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000057